



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/971

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Сангийн сайдын 2018 оны "Журам батлах тухай" 228 дугаар тушаалын 7.1 дахь заалтыг тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Мөнх-Эрдэнэ	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Д.Цэцэгсүрэн	-Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Өнөрцэцэг	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Б.Гүрсүрэн	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн
	Г.Лхагвабаатар	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	Д.Оюунжаргал	-Хүнс, хөдөө, аж ахуйн газрын мэргэжилтэн Иргэний нийгмийн төлөөлөл Иргэний төлөөлөл

2//.

2. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж, нийтэд нээлттэй хэлэлцүүлэн, олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА